



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 59

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5 дугаар зүйлийн 2.4, 8.г дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1970 онд ашиглалтанд орсон 894,608 /найман зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун найман/ төгрөгний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн грашийн барилгыг, Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2000 онд ашиглалтанд орсон 4,650,000 /дөрвөн сая зургаан зуун тавин мянган/ төгрөгний анхны өртөгтэй, 2,363,750 /хоёр сая гурван зуун жаран гурван мянга долоон зуун тавин төгрөг/-ний элэгдэлтэй, 2,286,250 /хоёр сая хоёр зуун наян зургаан мянга хоёр зуун тавин/ төгрөгний үлдэгдэл өртөгтэй Мааньт багийн конторын барилгыг тус тус акталж устгах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасах, гарсан материалыг эргэлтийн хөрөнгөнд зохих хууль журмын дагуу бүртгэж авахыг Сайхан-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн дарга /С.Мядагмаа/, ЗДТГ-ын дарга /С.Болоржаргал/ нарт тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



0100138